

ТАНИЛЦУУЛГА

“Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай

Ерөнхий зүйл.

Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 65 дугаар зүйлийн 65.3 дахь хэсэгт “Зөвлөл нь хараат бус, бие даасан байгууллага бөгөөд ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна...” гэж , мөн зүйлийн 65.4 дэх хэсэгт “Зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурал тогтооно” гэж тус тус заасныг үндэслэн тогтоолын төслийг боловсруулав.

Энэхүү тогтоолын төслийг **“Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал**”-ын дагуу боловсруулав.

Нэг. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүргийг тогтоох үндэслэлийн талаар

1.1. Зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүргийг тогтоох суурь үндэслэл.

Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэгт хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуулиар тогтоосон Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг нь хамрах хүрээ, агуулгаараа дор дурдсан **таван бүлэг асуудалд** хамаарах бүрэн эрх, чиг үүрэг байгаа нь тогтоогдов. Үүнд:

- I. Төрийн албаны удирдах ажилтны **манлайлалтай** холбогдсон бүрэн эрх, чиг үүргийн бүлэг;
- II. Төрийн албаны өөрчлөлт, шинэтгэлийн **бодлого, стратегитай** холбогдсон бүрэн эрх, чиг үүргийн бүлэг;
- III. Төрийн албаны бодлогыг хэрэгжүүлэх **арга-менежмент**, бүтэц тогтолцоог боловсронгуй болгохтой холбогдсон бүрэн эрх, чиг үүргийн бүлэг;
- IV. Төрийн албаны бодлогыг хэрэгжүүлэх **билэг-хүний нөөцийн хөгжилтэй** холбогдсон бүрэн эрх, чиг үүргийн бүлэг;
- V. Төрийн албаны **гүйцэтгэл, үр дүнтэй** холбогдсон бүрэн эрх, чиг үүрэг.

“Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийн бүлэг” (Хавсралт 2) нь Зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүргийг тогтооход харгалзан үзвэл зохих **суурь үндэслэл** нь болов.

1.2. Зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүргийг тогтоох гол үндэслэл.

Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харъяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн дарга-Төсвийн ерөнхийлөн захирагч нь зөвлөлийнхөө дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээж байгаа юм. Энэ үүргээ хэрэгжүүлэх зорилгоор Зөвлөлийн дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөний нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болох **“Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загвар”**-ын төслийг Төрийн албаны зөвлөл урьдчилан боловсруулсан байна.

Зөвлөлийн стратегийн энэ загварт Зөвлөлийн чиг үүрэгт хийсэн шинжилгээний үр дүнд тогтоосон бүрэн эрх, чиг үүргийн таван бүлэг тус бүрийг үндэслэн Зөвлөлийн **таван бодлогыг** тодорхойлсон байна. Үүнд:

- I. Шударга ёсны зарчимд тулгуурласан, орчны өөрчлөлтөд дасан зохицож чаддаг, **манлайлах ур чадвар сайтай төрийн албаны удирдах албан тушаалтны эгнээг өргөтгөх**, тэднийг бүх талаар хөхиүлэн дэмжих
- II. Хууль дээдлэх зарчимд тулгуурласан төрийн албаны өөрчлөлт, шинэтгэл, хөгжил, дэвшлийн **бодлого нь ард түмний хүсэл эрмэлзэлд нийцсэн байх**
- III. Бодлогыг хэрэгжүүлэх **арга -зөв менежментийг эзэмшиж хэрэглэх** замаар мэргэшсэн, тогтвортой байх зарчимд тулгуурласан төрийн албаны зохион байгуулалтын бүтэц, тогтолцоог бүрдүүлэх
- IV. Бодлогыг хэрэгжүүлэх **билэг -хүний нөөц буюу төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг тасралтгүй үргэлжлүүлэн хөгжүүлэх** замаар чадахуй (мерит)-н зарчимд тулгуурласан төрийн албан хаагчдын шинэ халааг төлөвшүүлэх
- V. Арга, билгийн нэгдлийг хангах замаар бүрдүүлсэн төрийн албаны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа (бизнес)-ны чадавхи нь **ард түмэнд үйлчлэх зарчимд нийцсэн монголын ард түмний итгэл, хүндэтгэлийг хүлээсэн гүйцэтгэл , үр дүнд хүргэдэг байх**

Дээр дурдсан **таван бодлого** тус бүрийн хэмжээнд баримтлах хоёр стратеги буюу нийт **10 стратеги**, 10 стратеги тус бүрийн хүрээнд хэрэглэх хоёр тактик буюу нийт **20 тактикийг** хуулиар тогтоосон Зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийг үндэслэн тодорхойлжээ.

Тэрчлэн Зөвлөлийн стратегийн загварын төсөлд **Зөвлөлийн гүйцэтгэл, үр дүн (10 гарц**, гарц тус бүрийн үзүүлэлт; **5 үр дагавар**, үр дагавар тус бүрийн үзүүлэлт; **2 нөлөө**, нөлөө тус бүрийн үзүүлэлт)-г тусгажээ.

Өөрөөр хэлбэл **“Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загвар”**-ын төсөлд тусгагдсан **5 бодлого, 10 стратеги, 20 тактик**, тэдгээрийн гүйцэтгэл, үр дүн (**10 гарц**, гарцын үзүүлэлт; **5 үр дагавар**, үр дагаврын үзүүлэлт; **2 нөлөө**, нөлөөний үзүүлэлт) нь Зөвлөлийн ажлын албаны үүрэг, чиг үүргийг тогтоох **гол үндэслэл** нь болов.

Хоёр. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүргийн талаар

2.1. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүргийг тогтоох **суурь үндэслэл** болон **гол үндэслэлд** тулгуурлан **“Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүрэг”-ийг** тогтоов

Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба нь Зөвлөлийн хуулиар тогтоосон бүрэн эрх, чиг үүргийн **таван бүлэг**, Төрийн албаны зөвлөлийн стратегийн загварын төслийн **таван бодлоготой** уялдсан **таван үүрэг** хүлээх бөгөөд таван үүрэг тус бүрийн хүрээнд Зөвлөлийн стратегийн загварын төслийн таван бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арван стратеги, хорин тактик буюу Зөвлөлийн хуулиар тогтоосон бүрэн эрх, чиг үүргээс урган гарсан чиг үүрэг (1 дэх үүргийн хүрээнд 7 чиг үүрэг; 2 дахь үүргийн хүрээнд 4 чиг үүрэг; 3 дахь үүргийн хүрээнд 7 чиг үүрэг; 4 дэх үүргийн хүрээнд 4 чиг үүрэг; 5 дахь үүргийн хүрээнд 4 чиг үүрэг)-ийг гүйцэтгэх болно.

2.2. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүрэг нь Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг тогтоох гол үндэслэл болов.

Гурав. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийн талаар

3.1. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны таван үүрэг, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй уялдуулан Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гаргалгааг хийв. Ажлын албаны ямар үүрэг, чиг үүргээс зохион байгуулалтын бүтцийн ямар нэгжийн гаргалгаа хийснийг **“Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн харилцан уялдаа холбооны бүдүүвч”-ээс** үзэж болох юм.

3.2. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн харилцан уялдаа холбоог үндэслэн Зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсан нэгжтэй байхаар тогтоох нь зүйтэй гэж үзэв:

- I. Төрийн албаны манлайлал, мэдээллийн нэгдсэн сангийн газар;**
- II. Төрийн албаны стратегийн удирдлагын газар;**
- III. Төрийн захиргааны удирдлагын газар;**
- IV. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын газар;**
- V. Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын газар.**

3.3. Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 65 дугаар зүйлийн 65.3 дахь хэсэгт “Зөвлөл нь ... ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна” гэж заасныг үндэслэн **“Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, түүний Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийн бүдүүвч”-ийг** боловсруулав.

Дөрөв. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны орон тооны дээд

хязгаарыг тогтоох талаар

4.1. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны үүрэг, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц нь Ажлын албаны орон тооны дээд хязгаарыг тогтоох гол үндэслэл болов.

4.2. Зөвлөлийн Ажлын албаны орон тооны дээд хязгаарын тооцооллыг Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийн нэгж тус бүрийн үүрэг, чиг үүрэгт үндэслэн хийж, Зөвлөлийн Ажлын албаны орон тооны дээд хязгаар нь Зөвлөлийн Сургалт, судалгааны нэгж (“Зөвлөл нь Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна” гэсний “...мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийг нь Зөвлөлийн Ажлын албаны “Төрийн албаны манлайлал, мэдээллийн нэгдсэн сангийн газар”-тай нэгтгэсэн болно”)-ийг оролцуулан нэгж орон тоотой байхаар тогтоох нь зүйтэй гэж үзэв.

“Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн болон Зөвлөлийн Сургалт, судалгааны нэгжийн орон тооны дээд хязгаар”-ыг албан тушаалын ангилал, зэрэглэл тус бүрээр тооцоолон гаргав. Үүн дээр Зөвлөлийн орон тооны таван гишүүнийг нэмж тооцвол Төрийн албаны зөвлөл, түүний Ажлын алба нь нийт орон тоотой болох юм.

“Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 70 дугаар тогтоолоор Зөвлөлийн Ажлын албаны орон тоог 14 нэгж орон тоотой байхаар тогтоосон.

Тав. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоохтой холбогдон гарах зардлын тооцоо

5.1. Бусад улс орнуудын төрийн албаны төв байгууллагын орон тоо нь манай улсынхаас хэт олон байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, Өмнөд Солонгосын Төрийн албаны Комиссын 5 агентлаг/алба, 15 салбарт нийт 353 ажилтан; Японы Үндэсний боловсон хүчний газарт нийт 689 ажилтан; Өмнөд Африкийн Төрийн албаны комисст нийт 200 ажилтан; Австралийн Төрийн албаны комисс, түүний 6 салбарт нийт 184 ажилтан; Канадын Холбооны Төрийн албаны комисст нийт 434 ажилтан тус тус ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан 5 улсын төрийн албаны төв байгууллага, тэдгээрийн ажлын алба нь 184-689 тоотой ажиллаж байгаа нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, түүний ажлын албаны 19 орон тооноос 9,6-36,2 дахин их байна. Судалгаанд хамрагдсан улс орнууд нь бүгд өндөр хөгжилтэй улс орнуудын эгнээнд багтаж байгаагаас үзэхэд тэдгээр улс орны төрийн албаны төв байгууллага нь чадавхи сайтай олон тооны ажиллагчдынхаа хүчээр өөр өөрсдийн орны төрийн албанд улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн гол хөтөч нь байх үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь болон улмаар төрийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах, эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн гишүүдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь өндөр мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж чадаж байгаагийн нотолгоо, төр нь ард түмнийхээ итгэл, хүндэтгэлийг хүлээж чадаж байгаагийн тод илрэл нь болж байна.

Зургаа. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг баталж, орон тооны дээд хязгаарыг тогтоон хэрэгжүүлснээр гарах үр дагавар

“Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараахь эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна:

6.1. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, төсөв ямар хэмжээгээр нэмэгдэж батлагдана Монгол Улсын Төрийн алба (2018 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг 4251 төсвийн байгууллагад 192475 төрийн албан хаагч ажиллаж байна)-нд Монгол Улсад өрнөж буй улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн **гол хөтөч** нь байх үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь Төрийн албаны зөвлөлөөс үзүүлдэг бүх талын дэмжлэг, мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээний хүртээмж, чанар мөн тэр хэмжээгээр нэмэгдэх эерэг үр дагаварт хүргэнэ гэж үзэж байна.

6.2. Энэ нь цаашлаад улс төрийн хүрээнд төрийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах; эдийн засгийн хүрээнд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах; нийгмийн хүрээнд ард түмний амьдралын чанарыг дээшлүүлэх чадавхитай, монголын ард түмний итгэл, хүндэтгэлийг хүлээсэн төрийн албыг Монгол Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд төлөвшүүлэх эерэг үр дагаварт хүргэх таатай нөхцлийг бүрдүүлэх болно.

6.3. Төрийн албаны төв байгууллагаас урьд өмнөхөөс хоёр дахин өргөтгөн үзүүлэх мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээний үр дүнд Монгол Улсын Төрийн албаны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд ямар эерэг өөрчлөлт гарснаар буюу нэг хүн амд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний болон дундаж цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлт, ажилгүйдэл, ядуурлын түвшингийн бууралт зэрэг ард түмний амьдралын чанарын шалгуур үзүүлэлтээр ажлаа үнэлж дүгнэх шинэ систем төрийн албанд нэвтэрч эхэлнэ.

Долоо. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц батлагдаж, орон тооны дээд хязгаар тогтоогдсон тохиолдолд зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал

7.1. “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2009 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 6 дугаар тогтоолыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарын төслийг боловсруулсан болно.

7.2. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар санал болгож буй хувилбараар батлагдсан тохиолдолд Төрийн албаны Зөвлөлийн Ажлын албанд шинээр буй болж байгаа “**Газрын дарга**”, “**Сургалт, судалгааны нэгжийн захирал**” гэсэн хоёр албан тушаалыг дээр дурдсан тогтоолд нэмж тусгах шаардлага үүснэ. Үүнтэй уялдуулан “**Тогтоолын хавсралтад**

өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

_____ оОо _____

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА**

Тогтоолын төсөл хүргүүлэх тухай

Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсгийг үндэслэн “Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан хүргүүлж байна.

Тогтоолын төслийг хянан үзэж, зохих журмын дагуу хэлэлцүүлэн баталж өгөхийг хүсье.

Хавсаргасан материал... хуудас болно.

Таныг Хүндэтгэсэн,

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Төрийн албаны зөвлөлийн
Ажлын албаны зохион байгуулалтын
бүтцийг батлах, орон тооны дээд
хязгаарыг тогтоох тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их хурлаас **ТОГТООХ** нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:
 - 1.1. Төрийн албаны манлайлал, мэдээллийн нэгдсэн сангийн газар;
 - 1.2. Төрийн албаны стратегийн удирдлагын газар;
 - 1.3. Төрийн захиргааны удирдлагын газар (Санхүү, дотоод аудитын хэлтэс, Гадаад харилцаа, хуулийн хэлтэстэйгээр);
 - 1.4. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын газар;
 - 1.5. Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын газар.

2. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны орон тооны дээд хязгаар (Зөвлөлийн Сургалт, судалгааны нэгжийн орон тоог оролцуулан)-ыг 40 байхаар тогтоосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 70 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэ тогтоолыг 2019 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг